

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/64/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 88013344 Цахим хаяг: erdenetsetseg.i@audit.mn Ахлах аудитор: Ш.Наран Утас: 99064808 Цахим хаяг: naran.sh@audit.gov.mn Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	19
3.5.3 Нэмэлт төсөв.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	21
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал .....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	24
4.5.1 Завсрын аудитын талаар.....	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	25
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	30

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
СБД	Сүхбаатар дүүрэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Ж.ТАМИР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/432  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлийн үр нөлөөг эс тооцвол, санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 92,801.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гурвалсан гэрээний 3 дугаар бүлгийн 3.3-т заасны дагуу нийт 15 түрээслэгчийн 54,263.5 мянган төгрөгийн барьцааг бүртгэж, тайлагнаагүй;
- Засгийн газрын хэвлэх үйлдвэрээс авах он дамжсан 6,050.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 0001/ХТ2024/0007 дугаар тогтоолоор иргэний нэхэмжлэлийн дагуу шийдвэрлэсэн Э-2205003545 дугаартай 205,447.7 мянган төгрөгийн 11,568.0 м2 газрыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл гаргуулан шийдвэрлээгүй;

- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,476,935.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй, хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 31.3.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5, 57.14, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Монгол улсын засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 10, 11 дүгээр хавсралт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1 дэх заалттай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын эрх шилжүүлэх тухай 2025 оны 95 дугаар тушаалаар батлагдсан 2,498,748.6 мянган төгрөгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд 5 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын нийтлэг үйлчилгээнд ашиглагдах хэвлэлийн тоног төхөөрөмж, хурлын их танхимын тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажил гүйцэтгүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газрын Төрийн ордны барилгын дээврийн засварт 251,011.8 мянган төгрөг, Засгийн газрын XII байрны цахилгааны шинэчлэлийн 569,969.7 мянган төгрөг, автомашины зам, авто зогсоолын засварт 854,731.4 мянган төгрөг нийт 1,675,712.9 мянган төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим, сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,579,845,266.02</b>	<b>4,662,640,136.65</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,471,271,133.00</b>	<b>85,258,612.25</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,471,271,133.00	85,258,612.25
31210	Төгрөг	2,471,271,133.00	85,258,612.25
31211	Төрийн сангийн харилцах	2,471,271,133.00	85,258,612.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>36,970,907.00</b>	<b>398,203,816.22</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	260,561,409.96
33500	Бусад авлага	36,970,907.00	137,642,406.26
33510	Байгууллагаас авах авлага	36,970,907.00	137,642,406.26
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,671,603,226.02</b>	<b>1,779,177,708.18</b>
35400	Хангамжийн материал	1,671,603,226.02	1,779,177,708.18
35410	Бичиг хэргийн материал	27,843,584.81	32,680,968.91
35420	Аж ахуйн материал	1,175,634,457.81	1,276,624,723.88
35430	Сэлбэг хэрэгсэл	188,666,651.78	123,216,169.18
35440	Түлш, шатах тослох материал	4,116,411.29	1,508,231.67
35450	Барилгын засварын материал	92,317,203.57	79,438,936.24
35460	Хүнсний материал	183,024,916.76	265,708,678.30
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>2,400,000,000.00</b>	<b>2,400,000,000.00</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,400,000,000.00	2,400,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,289,598,376.54</b>	<b>30,129,692,705.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>30,289,598,376.54</b>	<b>30,129,692,705.84</b>
39200	Биет хөрөнгө	27,178,918,912.54	27,019,366,604.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	30,076,425,920.45	30,076,425,920.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,989,476,200.79)	(5,752,792,765.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,235,963.17)	(29,855,110.87)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,708,390,162.52	2,288,092,402.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,026,798,788.15)	(928,340,492.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,295,873,005.22	2,311,524,527.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,748,608,772.57)	(1,780,978,165.97)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	249,850,862.00	249,850,862.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,888,354,132.04	1,908,784,877.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,278,855,445.01)	(1,353,345,449.59)
39300	Биет бус хөрөнгө	3,110,679,464.00	3,110,326,101.04
39301	Программ хангамж	37,526,829.85	32,776,829.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	(29,426,829.85)	(25,030,192.81)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,102,579,464.00	3,102,579,464.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>36,869,443,642.56</b>	<b>34,792,332,842.49</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,429,305,269.00</b>	<b>335,199,227.25</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,429,305,269.00</b>	<b>335,199,227.25</b>
41300	Өглөг	2,429,305,269.00	335,199,227.25
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	379,044.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,493,643.00
41360	Бусад өглөг	2,429,305,269.00	329,326,540.25
41361	Байгууллагад төлөх өглөг	2,429,305,269.00	329,326,540.25
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>34,440,138,373.56</b>	<b>34,457,133,615.24</b>

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>34,440,138,373.56</b>	<b>34,457,133,615.24</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	15,303,767,640.17	15,303,767,640.17
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	15,303,767,640.17	15,303,767,640.17
51200	Хуримтлагдсан үр дүн	1,126,605,193.80	1,143,600,435.48
51210	Өмнөх үеийн үр дүн	(469,073,472.21)	1,126,605,193.80
51220	Тайлант үеийн үр дүн	1,595,678,666.01	16,995,241.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,009,765,539.59	18,009,765,539.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>36,869,443,642.56</b>	<b>34,792,332,842.49</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>12,814,752,728.18</b>	<b>12,023,287,998.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,963,831,707.38</b>	<b>12,023,287,998.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,963,831,707.38</b>	<b>499,545,442.31</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	351,671,399.20	499,495,442.31
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	351,671,399.20	499,495,442.31
120009	Бусад орлого	2,600,751,975.00	50,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,408,333.18	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>11,523,742,555.89</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	11,523,742,555.89
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,593,203,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	8,593,203,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,930,539,255.89
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	204,762,636.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	793,576,400.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,932,200,219.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>9,850,921,020.80</b>	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,885,451,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,885,451,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,965,469,420.80	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,965,469,420.80	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,218,449,116.96</b>	<b>12,005,808,922.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,064,391,661.96</b>	<b>12,005,808,922.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,874,351,491.78</b>	<b>11,627,789,474.21</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,450,980,358.73	6,677,394,067.06
210101	Үндсэн цалин	1,424,706,051.67	1,258,230,037.87
210102	Нэмэгдэл	3,670,816,800.55	4,207,307,639.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	355,457,506.51	1,206,304,000.00
210104	Урамшуулал	-	5,552,390.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	680,408,995.88	845,665,961.78
210201	Тэтгэврийн даатгалын зардал	476,349,382.90	587,657,589.13
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	52,407,184.39	65,325,542.65
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	34,207,810.42	44,700,479.35
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	23,488,923.59	29,596,470.18
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	93,955,694.58	118,385,880.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	946,628,993.42	1,076,166,401.71
210301	Гэрэл, цахилгаан	498,502,880.91	648,388,645.82
210302	Түлш, халаалт	322,061,164.46	304,672,552.41
210303	Цэвэр, бохир ус	126,064,948.05	123,105,203.48
2104	Хангамж, бараа материалын зардал	788,266,033.92	1,117,861,385.71
210401	Бичиг хэрэг	16,989,653.42	23,196,535.26
210402	Тээвэр, шатахуун	9,351,121.62	16,384,350.62

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,408,076.09	8,897,717.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,248,700.00	19,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	652,376,930.14	1,029,600,692.73
210408	Бараа материал акталсны зардал	103,891,552.65	20,682,090.10
2105	Нормативт зардал	7,374,459.68	11,315,882.83
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,374,459.68	11,315,882.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	738,703,202.43	623,739,497.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,303,990.29	61,851,470.91
210604	Урсгал засвар	655,399,212.14	561,888,026.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,097,267.26	103,434,587.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,990,578.26	86,124,551.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	2,700,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,992,500.00
210807	Газрын төлбөр	12,106,689.00	11,617,536.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,101,892,180.46	1,172,211,689.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,455,803.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,101,892,180.46	1,153,755,886.30
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>246,964,136.00</b>	<b>245,875,656.00</b>
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	246,964,136.00	245,875,656.00
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	246,964,136.00	245,875,656.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>943,076,034.18</b>	<b>132,143,791.91</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	7,646,902.91
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	7,646,902.91
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	7,646,902.91
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	800,260.16
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	6,846,642.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	255,982,188.67	124,496,889.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	162,723,200.00	86,628,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,258,988.67	37,868,889.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	687,093,845.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	668,038,952.55	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,054,892.96	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>154,057,455.00</b>	<b>-</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	154,057,455.00	-
221001	Их засвар	154,057,455.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,596,303,611.22</b>	<b>17,479,076.08</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>624,945.21</b>	<b>483,834.40</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	624,945.21	483,834.40
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(624,945.21)</b>	<b>(483,834.40)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>1,595,678,666.01</b>	<b>16,995,241.68</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>13,027,192,616.80</b>	<b>13,920,666,102.14</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>575,519,621.00</b>	<b>13,920,666,102.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>575,519,621.00</b>	<b>688,657,325.25</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	519,519,621.00	603,348,713.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	519,519,621.00	603,348,713.00
120009	Бусад орлого	56,000,000.00	85,308,612.25
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>13,232,008,776.89</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	13,232,008,776.89
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,593,203,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	8,593,203,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,638,805,476.89
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	237,316,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,469,289,257.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,932,200,219.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>12,451,672,995.80</b>	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,486,203,575.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,885,451,600.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,600,751,975.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,965,469,420.80	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,965,469,420.80	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,271,775,808.80</b>	<b>11,479,338,643.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,271,775,808.80</b>	<b>11,479,338,643.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,077,963,460.29</b>	<b>10,810,608,828.02</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,533,122,693.96	6,821,420,038.10
210101	Үндсэн цалин	2,625,477,019.92	2,566,712,990.72
210102	Нэмэгдэл	2,111,968,530.87	2,802,134,535.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	389,049,777.95	1,192,212,591.01
210104	Урамшуулал	406,627,365.22	260,359,920.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	664,639,824.16	780,203,400.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	452,377,824.16	530,538,200.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	53,065,500.00	62,416,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	27,390,610.15	31,208,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,674,889.85	31,208,200.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	106,131,000.00	124,832,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	948,123,426.27	1,076,166,401.71
210301	Гэрэл, цахилгаан	498,045,693.33	648,388,645.82
210302	Түлш, халаалт	322,476,264.41	304,672,552.41
210303	Цэвэр, бохир ус	127,601,468.53	123,105,203.48
2104	Хангамж, бараа материалын зардал	1,058,168,051.50	1,142,806,096.90
210401	Бичиг хэрэг	2,363,500.00	3,758,050.00
210402	Тээвэр, шатахуун	35,396,734.00	25,849,501.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,783,300.00	7,292,923.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,248,700.00	9,568,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,375,817.50	1,096,337,222.90
2105	Нормативт зардал	22,476,000.00	35,334,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,476,000.00	35,334,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	477,071,715.34	488,723,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	137,785,777.34	34,953,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,867,000.00	23,590,145.76
210604	Урсгал засвар	316,418,938.00	430,179,694.24

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	374,361,749.06	444,790,651.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	348,489,249.06	428,347,860.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,700,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,100,000.00	4,739,490.40
210807	Газрын төлбөр	11,772,500.00	9,003,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	21,164,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	21,164,400.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>246,964,136.00</b>	<b>267,026,614.00</b>
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	246,964,136.00	267,026,614.00
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	246,964,136.00	267,026,614.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>946,848,212.51</b>	<b>401,703,201.87</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	27,001,384.87
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	27,001,384.87
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	27,001,384.87
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	800,260.16
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	6,846,642.75
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	19,354,481.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,754,367.00	133,494,889.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	169,840,067.00	95,626,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,914,300.00	37,868,889.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	687,093,845.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	668,038,952.55	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,054,892.96	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	241,206,928.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	241,206,928.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,755,416,808.00</b>	<b>2,441,327,458.25</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>359,385,675.00</b>	<b>4,827,339,979.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>359,385,675.00</b>	<b>4,827,339,979.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	359,385,675.00	4,827,339,979.00
221001	Их засвар	200,751,975.00	1,675,712,857.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,158,793,072.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	158,633,700.00	992,834,050.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(359,385,675.00)</b>	<b>(4,827,339,979.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,396,031,133.00</b>	<b>(2,386,012,520.75)</b>
<b>101</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>75,240,000.00</b>	<b>2,471,271,133.00</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,471,271,133.00</b>	<b>85,258,612.25</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	(469,073,472.21)	32,844,459,707.55
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	(469,073,472.21)	32,844,459,707.55
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,595,678,666.01	1,595,678,666.01
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	1,126,605,193.80	34,440,138,373.56
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	1,126,605,193.80	34,440,138,373.56
19	Тайлант үеийн үр дүн	-	-	16,995,241.68	16,995,241.68
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	1,143,600,435.48	34,457,133,615.24

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>9,410,113,100.00</b>	<b>8,928,725,138.84</b>	<b>481,387,961.16</b>	<b>94.9</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>9,410,113,100.00</b>	<b>8,928,725,138.84</b>	<b>481,387,961.16</b>	<b>94.9</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>300,000,000.00</b>	<b>336,322,099.00</b>	<b>(36,322,099.00)</b>	<b>112.1</b>
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	300,000,000.00	336,322,099.00	(36,322,099.00)	112.1
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>9,110,113,100.00</b>	<b>8,592,403,039.84</b>	<b>517,710,060.16</b>	<b>94.3</b>
122005	Төсвөөс санхүүжих	9,110,113,100.00	8,592,403,039.84	517,710,060.16	94.3
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,410,113,100.00</b>	<b>8,919,401,789.88</b>	<b>490,711,310.12</b>	<b>94.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,410,113,100.00</b>	<b>8,919,401,789.88</b>	<b>490,711,310.12</b>	<b>94.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,322,244,200.00</b>	<b>8,847,196,900.88</b>	<b>475,047,299.12</b>	<b>94.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,238,835,200.00	6,135,251,857.93	103,583,342.07	98.3
210101	Үндсэн цалин	2,730,572,500.00	2,566,712,990.72	163,859,509.28	94.0
210102	Нэмэгдэл	2,296,698,700.00	2,115,966,355.61	180,732,344.39	92.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	771,683,500.00	1,192,212,591.01	(420,529,091.01)	154.5
210104	Урамшуулал	439,880,500.00	260,359,920.59	179,520,579.41	59.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	780,203,400.00	780,203,400.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	530,538,200.00	530,538,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	62,416,200.00	62,416,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,208,200.00	31,208,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	31,208,200.00	31,208,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	124,832,600.00	124,832,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,294,984,800.00	1,076,166,401.71	218,818,398.29	83.1
210301	Гэрэл, цахилгаан	704,969,400.00	648,388,645.82	56,580,754.18	92.0
210302	Түлш, халаалт	441,138,000.00	304,672,552.41	136,465,447.59	69.1
210303	Цэвэр, бохир ус	148,877,400.00	123,105,203.48	25,772,196.52	82.7
2104	Хангамж, бараа материалын зардал	314,205,400.00	269,105,700.00	45,099,700.00	85.6
210401	Бичиг хэрэг	4,725,500.00	3,758,050.00	967,450.00	79.5
210402	Тээвэр, шатахуун	13,203,600.00	9,850,434.00	3,353,166.00	74.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,456,100.00	7,292,923.00	1,163,177.00	86.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,610,400.00	9,568,400.00	7,042,000.00	57.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	271,209,800.00	238,635,893.00	32,573,907.00	88.0
2105	Нормативт зардал	56,584,100.00	35,334,600.00	21,249,500.00	62.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,584,100.00	35,334,600.00	21,249,500.00	62.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	529,635,600.00	474,776,800.00	54,858,800.00	89.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,545,000.00	34,953,400.00	3,591,600.00	90.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,376,300.00	23,590,145.76	6,786,154.24	77.7
210604	Урсгал засвар	460,714,300.00	416,233,254.24	44,481,045.76	90.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,595,700.00	55,193,741.24	27,401,958.76	66.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,921,500.00	38,750,950.84	17,170,549.16	69.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2,700,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,970,000.00	4,739,490.40	7,230,509.60	39.6
210807	Газрын төлбөр	12,004,200.00	9,003,300.00	3,000,900.00	75.0

**Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,200,000.00	21,164,400.00	4,035,600.00	84.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,200,000.00	21,164,400.00	4,035,600.00	84.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,868,900.00</b>	<b>72,204,889.00</b>	<b>15,664,011.00</b>	<b>82.2</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,868,900.00	72,204,889.00	15,664,011.00	82.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,000,000.00	34,336,000.00	15,664,000.00	68.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,868,900.00	37,868,889.00	11.00	100.0
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>		<b>9,323,348.96</b>	<b>(9,323,348.96)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>(9,323,348.96)</b>	<b>9,323,348.96</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>		<b>(9,323,348.96)</b>	<b>9,323,348.96</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>215</b>	<b>215</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	42	42	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	172	172	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>215</b>	<b>215</b>	<b>-</b>	<b>100.0</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	209	209	-	100.0
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	6	6	-	100.0
<b>66</b>	<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.0</b>
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,169,516,219.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,169,516,219.89</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>2,169,516,219.89</b>
1221	Хандив тусламж /дотоод/	2,169,516,219.89
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,169,516,219.89
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,169,516,219.89
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,162,669,577.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,162,669,577.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,162,669,577.14</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686,168,180.17
210102	Нэмэгдэл	686,168,180.17
2104	Хангамж, бараа материалын зардал	873,700,396.90
210402	Тээвэр, шатахуун	15,999,067.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,701,329.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	213,204,090.00
210604	Урсгал засвар	213,204,090.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	389,596,910.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	389,596,910.07
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>6,846,642.75</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(6,846,642.75)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(6,846,642.75)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар нь Монгол Улсын Засгийн газрын нийтлэг үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба буюу Төрийн ордонд байрлах байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд нийтлэг үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Хэрэглэгчдэд үзүүлэх нийтлэг үйлчилгээг олон улсын стандартын түвшинд зохион байгуулж, үйлчилгээний үр ашигтай, зардал багатай, дэвшилтэт технологид суурилсан хэлбэрийг сонгож ажиллах;
- Төр, засгийн байгууллагын албан ажлын болон тусгай зориулалтын байрны нөхцөл, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний найдвартай хэвийн ажиллагааг хангах;
- Төр, засгийн байгууллага, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлэх, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Нийтлэг үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсний үндсэн дээр хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах, орчин үеийн дэвшилтэт технологи, арга хэлбэр, шинэ санааг нэвтрүүлэх;

Байгууллага нь 2025 онд 5 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж ажилласнаас 21 арга хэмжээг бүрэн хангалттай, 7 арга хэмжээг хангалттай, нийт 87.3 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт шинжилгээ үнэлгээний газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлээгүй байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар нь Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Ахмад настны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Барилгын тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай, Төрийн ордны тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон Монгол Улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар, Монгол Улсын засгийн газрын Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын талаар авах зарим арга хэмжээний талаар 2021 оны 11 дүгээр, Монгол Улсын засгийн газрын Төр, засгийн нийтлэг үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022 оны 400 дугаар тогтоолууд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өөрийн өмчийн эд

хөрөнгийг түрээслүүлэх тухай ТӨБЗГ-ын 2021 оны 134 дүгээр, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг тогтоох тухай ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Байгууллагын даргын 2024 оны А/51 дүгээр тушаалын хавсралтаар “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баталсан. Шалгагдагч байгууллагад дотоод хяналт үнэлгээний 1 ажилтан ажилладаг. Тайлант онд дотоод хяналт шалгалт, шинжилгээ үнэлгээг хэрэгжүүлэхээр 4 үндсэн зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөж, биелэлтийг сар бүр тайлагнаж ажилласан ба өмч хөрөнгө, санхүү бүртгэлийн үйл ажиллагааны талаар төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт, 3 арга хэмжээний гүйцэтгэлийг тайлагнаагүй байна. Тайлант онд Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хамрагдаж 92.59 хувийн үзүүлэлттэй дүгнэгдсэн байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төр, захиргааны үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Шалгагдагч байгууллагын даргын 2020 оны А/43 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан тушаал, заавар журам, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төр захиргааны үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,077,10.8 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	2,471,271.1	85,258.6	(2,386,012.5)
Авлага	36,970.9	398,203.8	361,232.9
Бараа материал	1,671,603.2	1,779,177.7	107,574.5
Бусад эргэлтийн хөрөнгө	2,400,000.0	2,400,000.0	-
Үндсэн хөрөнгө	30,289,598.4	30,129,692.7	(159,905.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>36,869,443.6</b>	<b>34,792,332.8</b>	<b>(2,077,110.8)</b>
Өр төлбөр	2,429,305.3	335,199.2	(2,094,106.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	34,440,138.4	34,457,133.6	16,995.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>36,869,443.6</b>	<b>34,792,332.8</b>	<b>(2,077,110.8)</b>

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 85,258.6 мянган төгрөг болж 2,386,012.5 мянган төгрөгөөр буурсан нь 5 аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн гэрээт ажлын төлбөрийн үлдэгдэл 2,300,753.9 мянган төгрөгийг барагдуулж, 3 компанийн барьцааны 85,258.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлсөн байна.
- Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 362,232.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын хэвлэх үйлдвэр татан буугдсантай холбоотойгоор шилжиж ирсэн 6,050.0 мянган төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэл, 3 аж ахуйн

нэгжээс авах 10,100.0 мянган төгрөгийн түрээсийн авлагын үлдэгдэл, Мэдээлэл технологийн үндэсний паркийн 14,000.0 мянган төгрөгийн залны түрээсийн төлбөр, СБД-ийн нийгмийн даатгалын хэлтэст илүү шилжүүлсэн 25,000.0 мянган төгрөг, Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн барилга засварын ажлын гүйцэтгэлээс дутуу санхүүжсэн 82,500.0 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны харилцах данснаас 250,500.0 мянган төгрөг, ахмадын сангийн харилцах данснаас 10,030.0 мянган төгрөгийг тус тус төсөвт татан төвлөрүүлж, өмнөх оны авлагын үлдэгдэлтэй 4 аж ахуйн нэгжийн 36,947.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 107,574.5 мянган төгрөгөөр өссөн нь 1,674,808.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,546,551.8 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж, Газрын даргын 2025 оны 12 сарын 31-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар 41 нэр төрлийн 101 ширхэг 20,682.0 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалсан байна.
- Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй нь "Маш нууц" зэрэглэлд хамаарах 2,400,000.0 мянган төгрөгийн ажлыг актаар хүлээж аваагүйгээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 159,905.7 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын хуралдааны танхимын тавилга 35,400.0 мянган төгрөг, төрийн хүндэтгэлийн өргөө тавилга 29,900 мянган төгрөг, Төрийн хүндэтгэлийн өргөө гэр 78,500.0 мянган төгрөг, архивын өрөөнд 4,800.0 мянган төгрөг, архивын нэгжид программ хангамж 1,500.0 мянган төгрөг, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолбор тавилга 10,200.0 мянган төгрөг, хэвлэх үйлдвэрт тоног төхөөрөмж 40,534.1 мянган төгрөгийн хөрөнгийг урсгал санхүүжилтээс бэлтгэж, хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж 199,900.0 мянган төгрөг, Их танхимын тоног төхөөрөмж 593,600.0 мянган төгрөг нийт 994,300 мянга төгрөгийн, хөрөнгө оруулалтаар бэлтгэж, ТӨБЗГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 588 тогтоолоор Сонгуулийн Ерөнхий хороонд 14 ширхэг ширээ 5,992.0 мянган төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлж, 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 843 тогтоолоор 164 нэрийн 426 ширхэг 377,307.5 төгрөгийн хөрөнгийг актлан, тайлант оны 1,153,755.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдлийн 2,094,106.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 13,349,402.8 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ худалдан авалтын өглөгийг бүртгэж, 15,443,508.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулан 335,199.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь ЗГХЭГ-ийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл 326,400.0 мянган, харилцагч 5 байгууллагад төлөх 8,400.0 мянган, 2 ажилчинтай холбоотой 300.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 16,995.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газар нь 2007 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс салхивчны агааржуулалтын систем, 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Эйблсофт ХХК-ийн мэдээллийн үйлчилгээний системийг ашиглаж байгаа ба дэлгэрэнгүй судалгааг Д301/04 дүгээр маягтаар баталгаажуулж, баримтжуулсан.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,658,067.9 мянган, үйл ажиллагааны орлогоос 175,000.0 мянган, нийт зарлагыг 9,833,067.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас норматив зардлыг 6,287.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 45,272.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 46,420.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 65,541.3 мянган төгрөг, эд хогшлын урсгал засварын зардлыг 67,555.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 117,809.2 мянган төгрөг, цалин хөлсний зардлыг 452,167.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 25,200.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 222,897.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 9,280,113.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 2025 оны 7 дугаар сард урсгал засварын зардалд 130,000.0 мянган төгрөгийг нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 9,110,113.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 300,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,583,879.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоор 335,522.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,919,401.8 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвөөс бараа үйлчилгээний бусад зардлыг 4,035.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 15,664.0 мянган төгрөг, норматив зардлыг 21,249.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 27,402.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 45,099.7 мянган төгрөг, эд хогшил,

урсгал засварын зардлыг 54,858.8 мянган төгрөг, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 103,583.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 218,818.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,655,011.1	8,161,612.3	493,398.8	94.3
2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	55,921.5	38,751.0	17,170.5	69.3
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	87,868.9	72,204.9	15,664.0	82.2
4	80834 Ерөнхийлөгч асанд хуулийн дагуу олгох цалин	311,311.6	311,311.6	-	100.0
5	120010 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	300,000.0	335,522.1	(35,522.1)	111.8
<b>НИЙТ ДҮН</b>		<b>9,410,113.1</b>	<b>8,919,401.8</b>	<b>490,711.3</b>	<b>94.8</b>

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Төр, захиргааны үйлчилгээг эрхлэх газрын даргын 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/1 дүгээр тушаалаар газрын ажил, албан тушаалын жагсаалтыг 215 орон тоотой ажиллахаар баталснаас гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 41, үйлчилгээний 173, нийт 215 орон тоотой ажилласан байна.
- Тус газрын 13.0 мянган төгрөгөөр мөрдөж байсан хоол унааны хөнгөлөлтийн тарифыг Газрын даргын 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 26.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлын батлагдсан төсөв хэмнэлттэй хэдий ч хоол унааны хөнгөлөлтийн зардал батлагдсан төсвөөс 420,529.1 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд ЗГХЭГ-аас засварын ажилд олгосон 237,316.0 мянган төгрөгийн санхүүжилт, Үндэсний баяр наадмын хорооноос үйлчилгээний төлбөрийн 186,000.0 мянган төгрөгийн, төрийн ордонд байрлах төрийн

байгууллагуудын цайны үйлчилгээ, өрөө тасалгааны засварын , зал танхимын үйлчилгээний төлбөрөөс болон бусад орлогоор 1,739,411.0 мянган төгрөгийн нийт 2,162,727.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, тээвэр шатахуунд 15,999.1 мянган төгрөг, урсгал засварт 213,204.1 мянган төгрөг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 389,596.9 мянган төгрөг, цалин хөлсөнд 686,168.2 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авахад 873,700.4 мянган төгрөг нийт 2,178,668.7 мянган төгрөгийг зарцуулж, 57,8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар нь тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 231,209.8 мянган төгрөгийн цэвэрлэгээний материалыг худалдан авахаар төлөвлөн, нээлттэй тендерийг 1 удаа удаа зохион байгуулж, тендерт шалгарсан “Түшээ мээрэн” ХХК-тай 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 212,301.8 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээг байгуулж, 199,814.1 мянган төгрөгийн цэвэрлэгээний материалыг худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төр, захиргааны үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах биет бус хөрөнгө, үндсэн хөрөнгө, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ дансны үлдэгдэлд Төрийн "Маш нууц"-д хамааралтай тул аудитын горим, сорил хэрэгжүүлээгүй.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго, аудитын менежер Г.Ариунболд нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, дараагийн шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг ДУНД гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 9,280,113.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 92,801.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан тайлант онд хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 376,770.1 мянган төгрөгийн зөрчлөөс 316,357.2 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага, 60,412.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсан мэдээлэх 169 мэдээллийг хугацаанд бүрэн байршуулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Илрүүлэлт: Тус байгууллага нь ахмадын сангийн журамгүйгээр Газрын даргын 30 удаагийн тушаалаар 60,412.9 мянган төгрөгийг ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3.3-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын 3.1.3, 3.1.9-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээг тогтоож, дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын онцлогт тохирсон Ахмадын сангийн журмыг боловсруулан мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2. Илрүүлэлт: Тайлант онд 20,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 316,357.2 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг 8 байгууллагаас тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаагүй холбогдох буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, шилэн данс, худалдан авах ажиллагаа, бараа материалын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 975,590.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 55,839.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд худалдан авах ажиллагаатай холбоотой 1 албан шаардлагаар хүргүүлсэн зөрчлийг таслан зогсоогоогүй, давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	55,839.5	-	-	-
<b>Нийт дүн</b>	1	55,839.5	-	-	-

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах 2 асуудлыг үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан байдал;
- Төрийн “Маш нууц”-д хамааралтай хөрөнгийн бүртгэл тайлагнал, үр дүн.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,178,146.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,178,146.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Шалгагдагч байгууллагын Төрийн албаны цалингийн нэгдсэн системд тайлагнасан, олговол зохих цалингийн дүн санхүүгийн үр дүнгийн тайлангаас 35,723.6 мянган төгрөгөөр илүү, гарт олгох цалин нь мөнгөн хөрөнгийн журналд тайлагнасан дүнгээс 340,438.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дугаар заалтуудтай нийцээгүй, УСНББОУС-2 "Мөнгөн гүйлгээний тайлан", санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй;
- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан заавар аргачлалын дагуу үнэн зөв, иж бүрэн тайлагнаагүй. Орлого, зардлын тодруулгыг мөнгөн сууриар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дугаар заалтуудтай нийцэхгүй, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй;
- Улсын төсөвт татан төвлөрүүлсэн харилцах дансны үлдэгдэл 241,206.9 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар тайлагнаагүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ЗГХЭГ-т төлөх өглөгийг хааж бичсэн нь санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан төвлөрүүлэх шилжүүлгийн дүн, мөнгөн гүйлгээний тайлангаас 251,238.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдэхэд нөлөөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 16 дугаар зүйлийн 16.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дугаар заалтуудтай нийцэхгүй УСНББОУС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн тайланг бэлтгээгүй, ерөнхий журналд бүртгэсэн нэмэлт санхүүжилтийн орлогын дүн санхүүгийн үр дүнгийн тайлангаас 121,693.1 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5, 6 дугаар зүйлийн 6.3.2 дугаар заалтуудтай нийцэхгүй, УСНББОУС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй;
- Санхүүгийн тайланд тайлагнасан үндсэн хөрөнгийн үлдэгдлийг, жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад барилга байгууламж 866.8 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 13,566.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 367,446.8 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 40,299.3 мянган төгрөг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нийт 422,178.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дүгээр заалттай нийцэхгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт - 17 "Үндсэн хөрөнгө", санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 2,890,345.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 207,962.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 2,682,383.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 2,890,345.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

## 5.1 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гурвалсан гэрээний 3 дугаар бүлгийн 3.3-т "Түрээслэгч нь үүргийн биелэлтийн баталгаа болгож 1(нэг)сарын төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана." гэж заасныг мөрдөөгүй, нийт 15 түрээслэгчийн 54,263.5 мянган төгрөгийн барьцааг бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3/-т "Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Түрээслэгч байгууллагуудын барьцаа хөрөнгийг байршуулаагүй, бүртгэж тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Шалгагдагч байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/2 дугаар тушаалаар ажилтнуудын үндсэн цалинг тогтоохдоо, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10,11 дүгээр хавсралтаар баталсан цалингийн шатлалыг мөрдөөгүйгээс 199 ажилтанд 147,649.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д "Доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно", 57.14-д "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Монгол улсын засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын " 10, 11 дүгээр хавсралт" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн албаны цалингийн шатлалыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Илрүүлэлт: Засгийн газрын хэвлэх үйлдвэрээс авах, он дамжсан 6,050.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үлдэгдлийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шалгагдагч байгууллагын даргын 2020 оны А/43 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан стандарт, заавар журам, байгууллагын үйл ажиллагааны болон бүртгэл тайлагналын онцлогт нийцээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар 3.1.9.-т "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг," 20 дугаар зүйлийн 20.2.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", УСНББОУС-3 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа"-ны 7-д" Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм" гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын

дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн хөрөнгийг зарцуулахгүйгээр шинэчлэн боловсруулах.

## **2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал**

### **2.1 Илрүүлэлт:**

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 0001/ХТ2024/0007 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн, Э-2205003545 дугаартай 205,447.7 мянган төгрөгийн 11,568.0 м2 газрыг нягтлан бодох бүртгэлээс хасаж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаарын зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", УСНББОУС1-ын 63-т" Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусд нь элэгдүүлэхээр сонголт хийж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 0001/ХТ2024/0007 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

### **2.2 Илрүүлэлт:**

Төв аймаг Аргалант сумын 2-р баг, Хөшөөт Долоон худгийн хөндий -1 Э-1402000380 дугаар бүхий 17.0 мянган м2 газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаарын зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", УСНББОУС1-ын 63-т" Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусад нь элэгдүүлэхээр сонголт хийж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эрх бүхий байгууллагаас эзэмшүүлсэн газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнах.

### **2.3 Илрүүлэлт:**

Байгууллагын нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй, Горхи тэрэлжид байршилтай 15.0 мянган м2 газар нь, Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 400 дугаар тогтоолоор татан буугдсан Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаарын зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", УСНББОУС1-ын 63-т "Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусд нь элэгдүүлэхээр сонголт хийж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй газрын гэрчилгээг өөрийн байгууллагын нэр дээр бүртгүүлэх.

### 3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,476,935.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" УСНББОУС1-ын 63-т" Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусд нь элэгдүүлэхээр сонголт хийж болно" гэж заасантай нийцээгүй санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хэмжилт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох саналыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Шалгагдагч байгууллагын Төрийн албаны цалингийн нэгдсэн системд тайлагнасан олговол зохих цалингийн дүн нь, санхүүгийн үр дүнгийн тайлангаас 35,723.6 мянган төгрөгөөр илүү, гарт олгох цалин нь мөнгөн хөрөнгийн журналд тайлагнасан дүнгээс 340,438.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	393,068.0	-	-	1	393,068.0	1	393,068.0	-	-	-	-
2	Шалгагдагч байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан заавар аргачлалын дагуу үнэн зөв, иж бүрэн тайлагнаагүй. Орлого, зардлын тодруулгыг мөнгөн сууриар тайлагнасан байна.	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
3	Улсын төсөвт татан төвлөрүүлсэн харилцах дансны үлдэгдэл 241,206.9 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар тайлагнаагүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ЗГХЭГ-т төлөх өглөгт хааж бичсэн байна. Үүний улмаас үр дүнгийн тайланд тайлагнасан төвлөрүүлэх шилжүүлгийн дүн, мөнгөн гүйлгээний тайлангаас 251,238.1 мянган төгрөгөөр дутуу байна.	1	241,206.9	-	-	1	241,206.9	1	241,206.9	-	-	-	-

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Шалгагдагч байгууллага нь нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрүүлсэн орлого, зарлагын гүйлгээний тайланг бэлтгээгүй, ерөнхий журналд бүртгэсэн нэмэлт санхүүжилтийн орлогын дүн санхүүгийн үр дүнгийн тайлангаас 121,693.1 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	1	121,693.1	-	-	1	121,693.1	1	121,693.1	-	-	-	-
5	Санхүүгийн тайланд тайлагнасан үндсэн хөрөнгийн үлдэгдлийг, жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад барилга байгууламж 866.8 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 13,566.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 367,446.8 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 40,299.3 мянган төгрөг нийт 422,178.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.	1	422,178.8	-	-	1	422,178.8	1	422,178.8	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>1,178,146.8</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>1,178,146.8</b>	<b>5</b>	<b>1,178,146.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо			
1	Шалгагдагч байгууллагын даргын 2020 оны А/43 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэн батлагдсан стандарт, заавар журам, байгууллагын үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын онцлогт нийцээгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гурвалсан гэрээний 3 дугаар бүлгийн 3.3-т "Түрээслэгч нь үүргийн биелэлтийн баталгаа болгож 1(нэг)сарын төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана." гэж заасныг мөрдөөгүй, нийт 15 түрээслэгчийн 54,263.5 мянган төгрөгийн барьцааг бүртгэж тайлагнаагүй, байна.	1	54,263.5	-	-	1	54,263.5	-	-	-	-	-	-	-
3	Шалгагдагч байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/2 дугаар тушаалаар ажилтнуудын үндсэн цалинг тогтооходоо, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10,11 дүгээр хавсралтаар баталсан цалингийн шатлалыг мөрдөөгүйгээс 199 ажилтанд 147,649.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	147,649.0	-	-	1	147,649.0	-	-	-	-	-	-	-

Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 0001/ХТ2024/0007 дугаар тогтоолоор Э-2205003545 дугаартай 205,447.7 мянган төгрөгийн 11,568.0 м2 газрыг нягтлан бодох бүртгэлээс хасаж бүртгээгүй байна.	1	205,447.7	-	-			1	205,447.7	-	-	-	-
5	Төв аймаг Аргалант сумын 2-р баг, Хөшөөт Долоон худгийн хөндий -1 Э-1402000380 дугаар бүхий 17.0 мянган м2 газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	1	-	-	-			1	-	-	-	-	-
6	Монгол Улсын засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 400 дугаар тогтоолоор татан буугдсан Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй Горхи тэрэлжид байршилтай 15.0 мянган м2 газрын гэрчилгээнд өөрчлөлт оруулаагүй байна.	1	-	-	-			1	-	-	-	-	-
7	Он дамжсан Засгийн газрын хэвлэх үйлдвэрээс авах 6,050.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	6,050.0	-	-	1	6,050.0			-	-	-	-
8	Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,476,935.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй байна.	1	2,476,935.7	-	-			1	2,476,935.7	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>8</b>	<b>2,890,345.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>207,962.5</b>	<b>5</b>	<b>2,682,383.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
	<b>Дүн</b>						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Тус байгууллага нь ахмадын сангийн журамгүйгээр Газрын даргын 30 удаагийн тушаалаар 60,412.9 мянган төгрөгийг ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан байна.	1	60,412.9	-	-	1	60,412.9
2	Тайлант онд 20 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 316,357.2 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг 8 байгууллагаас тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авсан байна.	1	316,357.2	1	316,357.2	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>376,770.1</b>	<b>1</b>	<b>316,357.2</b>	<b>1</b>	<b>60,412.9</b>
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>376,770.1</b>	<b>1</b>	<b>316,357.2</b>	<b>1</b>	<b>60,412.9</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 503/АДИСО122

Улаанбаатар хот

САГ - 2026/64/НА - СТА - ТӨА

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Он дамжсан Засгийн газрын хэвлэх үйлдвэрээс авах 6,050,000.00 /Зургаан сая тавин мянган/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Он дамжсан авлагыг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга /Ж.Тамир/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /Г.Ариунаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 504/АД150122

Улаанбаатар хот

САГ - 2026/64/НА - СТА - ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгийн түрээсийн гурвалсан гэрээний 3 дугаар бүлгийн 3.3-т "Түрээслэгч нь үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 (нэг) сарын төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана." гэж заасныг мөрдөөгүй, нийт 15 түрээслэгчийн 54,263,470.00/Тавин дөрвөн сая хоёр зуун жаран гурван мянга дөрвөн зуун далан/ төгрөгийн барьцааг бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3/-т" Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээслэгч байгууллагын барьцаа хөрөнгийг байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга /Ж.Тамир/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /Г.Ариунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-91.Docx

1526181049



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 505/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/64/НА-СТА-ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/2 дугаар тушаалаар ажилтнуудын үндсэн цалинг тогтоохдоо, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10, 11 дүгээр хавсралтаар баталсан цалингийн шатлалыг мөрдөөгүйгээс 199 ажилтанд 147,649,043.00/Нэг зуун дөчин долоон сая зургаан зуун дөчин есөн мянга дөчин гурван/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д "Доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно", 57.14-д "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын "10, 11 дүгээр хавсралт" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн албаны цалингийн шатлалыг мөрдөөгүй, илүү цалин олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга /Ж.Тамир/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /Г.Ариунаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-91.Docx

1526181051



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 506/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/64/НА-СТА - ТВА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 20 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 316,357,220.00 (гурван зуун арван зургаан сая гурван зуун тавин долоон мянга хоёр зуун хорин) төгрөгийн бараа ажил үйлчилгээг 8 байгууллагаас тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж заасныг мөрдөөгүй, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", гэж хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ"-т гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын эдийн засагч (Б.Болорцэцэг)-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга (Ж.Тамир)-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

С.ТУНГАЛАГ